



САЙХАН-ОВОО СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.САРНАЙ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.14

№ 01/18

ДУА - 2017/102/СТА - ТЧЗ

Г Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бурэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайхан-Овоо сумын Цэцэрлэгийн 2016 оны санхүүгийн тайландауд аудит хийх явцад хүнсний материалыг цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг нормоор бодоогүй, хяналтгүй зарцуулж 22,367,720.00 төгрөгийн зардалд тайлагнасан байна.

Эн нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад /1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг/, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/ заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага огөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага огөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн A/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага огөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

- Холбогдох стандарт, журмын дагуу хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг нормоор бодож зарцуулалтад хяналт тавьж хэвших.

000000037


2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 04 дүгээр сарын 05-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д.Сарнай, нягтлан бодогч Г.Бум-Аюуш нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ШИНЖЭЭЧ  ЖУГАТХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ  Д.САРНАЙ
НЯГТЛАН БОДОГЧ  Г.БУМ-АЮУШ
ДУНДГОВ АЙМАГ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.